



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 25 өдөр

Дугаар A/264

Улаанбаатар хот

┌ Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн ┐  
хариуцсан комиссын бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 3.3.7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дэргэдэх “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Нийслэлийн өмчийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж ажиллахыг комиссын дарга /Д.Төмөрбаатар/- д даалгасугай.

3. Комиссын гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг ханган, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд холбогдох хөрөнгийн хөдөлгөөн хийгдсэн эсэхэд хяналт тавьж, татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулах, хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын тайланг улирал бүр танилцуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэст үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/81 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ




Ш.ҮНЭНБАТ

Тушаал-2019

11505000084

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
газрын даргын 2019 оны 07 дугаар сарын  
05 -ний өдрийн А/А.67 тушаалын хавсралт



Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан  
комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга:

Д.Төмөрбаатар

Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч

Комиссын орлогч дарга:

Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын хэлтсийн  
даргын үүрэг гүйцэтгэгч

Гишүүд:

Х.Жаргалсайхан

Захиргаа санхүүгийн хэлтсийн даргын үүрэг  
гүйцэтгэгч

М.Энхболд

Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн даргын  
үүрэг гүйцэтгэгч

Д.Итгэл

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн даргын үүрэг  
гүйцэтгэгч

Н.Раднаасэд

Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын хэлтсийн  
ахлах мэргэжилтэн

Комиссын нарийн бичиг:

Ч.Чулуунтөгс

Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын хэлтсийн  
мэргэжилтэн